

тай бага хүү Батбаатар нар ийнхүү төрсөн эхээ 80 нас хүрч байхад ирж золгосон юм. Их охин нь болох малчин Дашмаагийн төрүүлсэн охин Алтанцэцэг одоо Өвөр Монголын Хөх хотод нэртэй дуучин болоод байна. Буурал ээж Мөөг гуайн гэдсэнд 5 сартай БНМАУ-ын торгон хил алхаж ирсэн хүү нь өнөөдөр хотын барилгын газар мэргэжилтнээр ажиллаж байгаа Лундаажанцан юм.

Зуугийн тал насалж яваа гурван хүүхэд нь 80 хүрсэн буурал эхтэйгээ золгож, өвөрт нь ээлжлэн унтаж байгааг бодоход улс хоорондын харилцаанд муу уршиг бий болбол ард түмэн зовдог юм байна гэсэн нэгэн сэтгэлийг эерийн эрхгүй төрүүлж байлаа. Элэг дэвтээн эх үрсийг уулзуулсан өнөөгийн энэ бодлого хувирч өөрчлөгдөхгүй үргэлжилсээр байгаасай гэж хоёр улсын ард түмэн хүснэ.

Эх үрсийн амьдын хагацал гэдгийг бие сэтгэлээр туулсан Ёндон гуай «Би эхээс 6 настай өнчрөн хоцорсон тэртээ 44 жилийн өмнөс хойш өнөөдрийг хүртэл энэ ертөнц дээр тоос хөдөлгөж амьдрахдаа олон гомдож, олон уйлж, мөн ч зарим үед баярлаж явсан. Энэ уулзалт шиг том баяр насандаа үзсэнгүй. Эцэг эх, эх орноосоо хагацах шиг хэцүү юм хүнд байдаггүй байх гэж эхийгээ, өөрийгөө, эгч дүүгээ хараад бодогддог болсон. Улс орнууд бие биеэ ойлгож, ард түмнүүд аз жаргалтай, энх тайван байгаасай л гэж хүсэх юм» гэж ярьсан нь юм үзсэн хүний захиас үг гэж бодогдоно.

Монгол, Хятад хоёр улсын найрамдалт харилцаа 1980-аад оноос олон талаар сэргэж, зарим талаар сайжирч байгаа нь хүмүүст өндөр сэтгэл төрүүлж байна. Монголын ард түмэн хоёр орны найрамдлыг сайн сайхан байлгахын төлөө байгаа бөгөөд үүний дотор худалдаа соёл, урлаг, биеийн тамирын талаар хамтран ажиллахыг нэн чухалд үзэж байгаа юм. Олон жил хаалттай байсан хоёр улсын хил нээгдэж, ард түмэн уулзан учирч, бие биеийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй, бүх зүйлийг үнэн мөнөөр нь ярьж, хэлэлцэж, найрсаг сайхнаар аж төрөх нөхцөл бололцоо бүрдсэн сүүлийн хэдэн жилийн баярт үйл явдлыг гүнзгийрүүлэн батжуулах гэсэн ард түмний хүсэл эрмэлзлэлд нийцүүлэн бичсэн эл өгүүллийн сүүлийг энд хурааж хоёр улсын ард түмэнд эрхэм ёс, энх тайвныг бэлэгдэн ерөөж үгээ дуусган үзгээ эвхэв.

Улаанбаатар 1989 он .

ХОККАЙДОГООР АЯЛСАН МИНЬ

М. Нарантуяа

1988 оны 8-р сарын 17-ноос 9-р сарын 4-нийг хүртэл Японы хамгийн том арал болох Хоккайдоогоор аялах завшаан надад таарав. Жил бүр оюутны зуны амралтаар Хоккайдогийн «олон улсын харилцааны төв»-өөс Япон орныг үзэж, япон гэр бүлд амьдарч тэдний зан заншил, аж байдалтай танилцуулах зорилгоор «Хоум Стэй» буюу «Хоум»-айл,

гэр, «Стэй»-сууж амьдрах гэдэг нэртэй программыг зохион байгуулдаг.

Анх 1979 онд «Васэда»-гийн их сургуульд сурч байсан (Японы хамгийн том хувийн их сургуулиудын нэг) гадаадын 16 оюутан Хоккайдогийн «Нанаэче» гэдэг газар «Хоум стэй» хийсэн нь уг программын эхлэл болжээ.

1987 онд Хоккайдод 30-аад орны 224 оюутан очсон ба 1988 онд 40-өөд орны 280 оюутан болж нэмэгджээ.

Ийнхүү 1988 оны 8-р сарын 17-нд АНУ, Тайвань, Гонконг, Өмнөд Солонгос, Хятад зэрэг 40 орны оюутнуудтай хамт «Саппоромару» хөлөг онгоцонд сууж аяллаа эхлэв. 11000 тонны даацтай энэхүү хөлөг онгоц нь нийтдээ 800-аад хүний суудалтай. Дотроо европ, япон маягаар зассан өрөө, ресторан, тоглоомын танхим кино заал, бассейнтай. Анх удаа том хөлөг онгоцонд сууж Номхон далайгаар аялж байгаа миний хувьд бүх юм сонирхолтой байлаа. Зах хязгаар нь үл харагдах их далайг харахад эх орны маань өргөн уудам тал нутаг өөрийн эрхгүй санаанд минь бууна. Гадаадын оюутнуудтай ярилцах ялдамд «Монгол гэдэг улс байдаг юм уу?», «Хятадын нэг хэсэг биш үү?», « Монгол хүн бидэнтэй хамт явж байдаг ямар сонин юм бэ?» гэх мэтээр гайхаж байв. Нэг энэтхэг залуу «Монголд коммунист нам байдаг уу? Би коммунист намд дуртай», хөлөг онгоцны дарга; «япончуудыг монголоос гаралтай гэдэг нь яг үнэн юм байна. Их адилхан юм» гэх зэргээр ярьж байв. Гадаад орнуудад улс орноо сурталчлах нь маш чухал юм байна гэдгийг би тэгэхэд мэдэрч эх орныхоо тухай чадах ядахаараа ярьж өгч байлаа. Бид хөлөг онгоцоор 30 цаг явж боомтонд буугаад тэндээсээ автобусанд сууж, Хоккайдо арлын 70 гаруй хотод таран явцгаав. Бидний 8 хүн Хоккайдогийн зүүн хойд талд оршдог Китами хотод очлоо. (Тайвань, АНУ, Өмнөд Солонгос, Хятад, Индонез, Монгол) Улс улсын далбаа барьсан 10 хүн биднийг угтав. Намайг хүлээн авсан гэр бүл нь «Хоум Стэй» программыг Китами хотод анх зохион байгуулсан ажээ. Гэрийн эзний нэрийг Кикучи Такаши, Китамигийн аж үйлдвэрийн дээд сургуульд багшилдаг, 47 настай. Кикучи гуайн гэрт ороход юуны түрүүн хананд өлгөөстэй жаазтай зургууд нүднээ туслаа. Зөвлөлтийн пионерүүдтэй Артек зусланд авахуулсан зураг байв. Мөн модон «матрешка» тоглоом янз бүрээрээ байв. «Токио явснаас Зөвлөлт рүү явсан маань олон байх» гэж тэр ярьж байлаа. Байшин нь 2 давхар. Доод давхарт зочдын өрөө, эцэг, эхийн өрөө, 2-р давхарт хүүхдүүдийн өрөө тус тус байдаг. Их үнэ цэнэтэй элдэв янзын эд хогшилгүй хэрнээ маш тохилог цэвэрхэн суух юм. Эхнэр нь 45 настай, эрүүл ахуйн эмч, 2 хүүхэдтэй. Охин нь сургуулиа төгссөн тул ажил хийдэг. Хүү нь дунд сургуульд сурдаг. Монгол хүн ирэхийг сонсоод ном сэтгүүл уншиж бэлтгэе гэтэл манай орны тухай танилцуулга олдоогүй гэнэ. Харин япон монгол хэлний ярианы дэвтэр олж монголоор хэдэн үг бичээд ханан дээрээ хадсан байв. Зочид ирэхэд хамгийн хүндэтгэн барьдаг хоол нь түүхий загас (Сашими) юм. Япон маягийн жижиг ширээн дээр төрөл бүрээр чимсэн хоол ундны зүйл өрснийг хараад «япон хүн амаараа биш нүдээрээ иддэг» гэж ярьдаг нь санаанд оров. Япончууд хоолны гадаад үзэмжинд үнэхээр их санаа тавьдаг нь илт харагдана, Хэрвээ бууз, хуушуурыг төрөл бүрийн навч, ногоогоор чимвэл сайхан л харагдах юм байна даа гэсэн сэтгэгдэл бас төрж билээ. Хоол

идэх зуур надаас янз бүрийн юм асууж байв. «Монгол гэдэг нэр дунд сургуулийн түүхийн номонд Чингис хааны тухай бичигдсэн хэсэгт л гардаг. Одоо ер нь ямар орон байгааг ихэд сонирхож байв. Монголын тухай япон хэл дээр хэвлэгдсэн танилцуулгыг өгөхөд ихэд сонирхон уншаад: «танайд эмнэлэг, сургууль үнэ төлбөргүй байдаг юм уу?, хүүхэд төрүүлэхэд цалинтай амралт олгодог юм уу?» гээд л маш гайхаж байлаа. Энд байх хугацаанд эх орныхоо тухай сайн ярьж өгөх хэрэгтэй юм байна гэж бодогдоно.

Тэд нар маргаашнаас эхлээд миний юу хийхийг бүгдийг төлөвлөчихсэн байсан хэдий ч миний саналыг асуухад, би: «надад юм болгон сонирхолтой байна. Хоккайдод ирсэн энэ завшааныг ашиглан аль болох их юм үзмээр байгаа» гэхэд минь тэд маш баярлав.

Намайг охиныхоо өрөөнд түр байрлуулахаар бэлтгэж зассан нь саруулхан, цэвэрхэн тохитой өрөө байв. Япон айлд ирээд тэдний нэг өрөөнд нь унтаж байна гэхэд зүүд зэрэглээ мэт санагдана. «Япон айлд оронгуут танай гэрт хоёр долоо хоног амьдарч тав тухыг чинь алдагдуулах болсонд уучлагтун» гэж хэлээд шал тултал мэхийн ёслох хэрэгтэй. «Усанд орохдоо хамгийн сүүлд орох хэрэгтэй» гэж сануулж байсан билээ. Гэтэл намайг хүлээж авсан энэ гэр бүл нь маш энгийн, элэгсэг дотно байсан учир заалгасан зүйл маань хэрэг болсонгүй. Хоккайдогойн уур амьсгал манайхтай их төстэй, өдөр нь төөнөм халуун атлаа оройдоо жихүүн хүйтэн болох юм. Өглөө босоод гадагш гарахад нэлээд сэрүүн боловч биеийн тамирын талбайд очиход олон хүн цугларчихсан, зарим нэг нь гимнастик, нөгөө хэсэг нь бүжгийн сургууль зэрэг өөр өөрсдийн дуртай зүйлээ хийцгээж байна. Би ч гэсэн биеийн чилээг гарган гар хөлөө хөдөлгөчихөөд буцаж ирэхэд өглөөний хоол бэлэн болчихсон байлаа.

Япончууд өглөө, өдөр, орой өдөрт 3 удаа цагаан будааг тогтмол хэрэглэж заншжээ. Мөн хоол хүнсэндээ, шарсан загас, дарсан ногоо, бусад олон төрлийн жимс жимсгэнэ, ногоог их хэмжээгээр хэрэглэнэ. Хоолыг хийхдээ витамин ихтэй, калори багатайг онцлон анхаарах юм. Мөн сүү тараг багагүй хэрэглэнэ. Нутгаасаа холдохдоо япончууд хамгийн түрүүн «офуро»*-гаа, дараа нь цагаан будаа, давсалсан ногоогоо санадаг гэнэ. Хоолоо идээд хотын даргатай уулзахаар гарч. 10—15 минутын дараа гэхэд хотын захиргааны 6 давхар байшинд хүрч очив. Хаалганы хажууд цусны даралт хэмждэг багаж хэрэгслэл нүднээ тусна. Энд ирсэн хэн боловч даралтаа чөлөөтэй үзэж болно. Үүнээс гадна 7 хоногийн лхагва гаригт хотын оршин суугчдын эрүүл мэндийг үнэ төлбөргүй үзэж, зөвлөлгөө өгдөг ажээ.

Хотын даргатай уулзахаар дээшээ гарахад орон нутгийн сонин, телевизийн сурвалжлагч нар цугларсан байлаа. Хотын даргатай уулзсан бидний уулзалт маш элэгсэг дотно байдалд болж өнгөрөв. Бид бүгд л өөр өөрсдийн орны тухай ярьж өгөв. БНМАУ-аас ирсэн гэхэд минь маш гайхаж «Хаана байдаг юм бэ? гэж асууж байв. Тэгэхэд би Монголын тухай ярьж өгөв, Бас л «Япончууд Монголоос гаралтай гэсэн яг үнэн байна. Адилхан юм» гэж ярьж байв. Дараа нь хотынхоо тухай дэлгэрэнгүй ярьж танилцууллаа.

*Офуро-япон маягийн халуун усны газар, тэнд онгоцоо халаасан усаар дүүргэнэ. Эхлээд биеэ сайтар угаагаад дараа нь онгоцондоо орж сууна. Өдөрт нэг удаа дүүргээд бүгд ээлжээр орно.

Хотын даргатай уулзсаны дараа «Саппоро рамэн» гэдэг хоолны газар руу явав, «Рамэн» нь хятад хоол бөгөөд нарийн урт гоймон юм. «Саппоро» (Хоккайдогийн хамгийн том хот буюу нийслэл)-д японы хамгийн амттай рамэн үйлдвэрлэдэг гэнэ.

Рамэн гэдэг хоолны газар олон байдаг боловч, шөлөөрөө ялгагддаг бөгөөд голдуу үхрийн яс чанаж шөл гаргаад дотор нь гоймонгоо урт чигээр нь чанадаг ажээ. Дээрээс нь хэрчсэн мах хийвэл нэг янзын хоол, өндөг хийвэл бас нэг янзын хоол гэх зэргээр олон төрөл байдаг. Шөл нь жан, цуу, давстай гэж 3 янз байдаг.

Орой нь бидний үзсэн «О-бон» гэдэг баяр нь нас нөгчсөн төрөл төрөгсдийгөө санаж дурсах, тэдэнтэй «уулзаж», тэдэнд талархлаа илэрхийлдэг ёслол юм. Энэ баяр 8-р сарын 13-наас 17-ны өдрүүдэд болдог байна. Баярт оролцогсод японы үндэсний хувцас, японы үлгэрийн баатруудын баг гээд л янз бүрийн өмсгөлтэй харагдана. Энэ баярын нэг онцлог нь оролцсон бүх хүмүүсийг шагнаж урамшуулдаг. Хоол унд нь үнэ төлбөргүй. Төрөл бүрийн тоглоом тоглуулж, таавар таалгаж, үндэстний дуугаа дуулж, бүжиглэнэ.

«Хоум Стэй» прогаммын дагуу Китами хотын «Сансан-плаза» гэдэг хүнсний их дэлгүүрт ажиллаж үзэв. Дэлгүүрийн эрхлэгчийн өрөөнд ороход хананд өлгөөстэй зүйл нүдэнд тусав.

«Худалдан авагчийг баярлуулахад:

1. Элэгсэг дотно үйлчлэх
2. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн сар өдрийг заавал тавих, барааны чанарыг сайтар шалгах,
3. Хамгийн эрэлт хэрэгцээтэй барааг худалдаалах,
4. Хүнсний барааны хадгалалтад анхаарах зэргийг гол зарчмаа болгон ажиллана» гэжээ. «Худалдан авагчийн хамгийн хэрэгцээт зүйлийг зарж, хамгийн боловсон үйлчилгээг нэвтрүүлж, худалдан авагчийн итгэлийг хүлээх нь бидний гол зорилго» гэж дэлгүүрийн эрхлэгч ярьж байв.

«Сан-сан» дэлгүүр нь «Мишима» гэдэг пүүст хамаарагддаг. Мишима пүүст шинээр ажилд орох хүмүүс дараах тангараг өргөнө.

1. Бид сайн ажилласнаараа нийгэмд хувь нэмэр оруулна.
2. Нэгэн том гэр бүлийн гишүүний хувьд пүүсийнхээ нэр хүндийг ямагт өндөр өргөж явна.
3. Бид худалдан авагч, худалдаж байгаа бараандаа үргэлж баярлаж явна.
4. Бид соёлч боловсон үйлчилж, сахилга батыг чанд сахина.
5. Бид худалдан авагчийн итгэл найдварыг хүлээж чадна.
6. Бидний ажлын гол үзүүлэлт нь худалдан авагчийн чинээлэг хангалуун амьдрал мөн.

«Мишима» пүүс нь Хоккайдогийн 8 хотод хүнсний их дэлгүүртэй бөгөөд миний ажилласан дэлгүүр нь 1976 онд байгуулагдсан нийт 2,250 х. д. м талбайтай, жилд 20 трилл иены 8000 нэр төрлийн бараа худалдаалдгаас 14% -ыг загас, 13 9% -ыг мах, 15% -ийг ногоо, 40 %-ыг чихэр, 16% -ыг хагас боловсруулсан бүтээгдэхүүн, 8% -ыг соёлын бараа эзэлнэ. Загас ногоог захаас шууд авч зардаг юм байна. Худалдан авагчийн хэрэгцээнээс шалтгаалж үнэ нь өсч буурна.

«Сан-сан» дэлгүүр 6 тасагтай, түүний 3-т нь би ажиллаж үзэв. Үүнд-загасны махаар хагас боловсруулсан бүтээгдэхүүн хийх та-

саг, талхны тасаг, дэлгүүрийн дэргэдэх цайны газар тус тус болно. Өглөө 10 цагт дэлгүүр онгойдог бөгөөд 9 цаг өнгөрөөж ажилчид нь цугларна. Долоо хоногт нэг удаа 9 цаг 45 минутад дэлгүүрийн дарга яриа хийдэг. 10 цаг гэхэд худалдаа хийхэд бэлэн болчихсон байна.

Жишээ нь: талхны тасагт гурилаа зуураад тавьчихсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх тасаг бэлтгэл ажлаа дуусгачихсан (мах хэрчих, ногоо арилгах, гурил зуурах гэх зэрэг), цайны газар рамэний шөл чаначихсан байдаг юм байна. Дэлгүүр онгойход дэлгүүрийн дарга худалдагчдын хамт худалдан авагчдыг угтан авч заншжээ. Тэрээр худалдаа хийж буй танхимаар явах, цэвэрлэгээ хийх, худалдан авагчдад бараа сонгоход нь туслах зэргээр ажлын талбарт байнга явж харагдана. Ажилчид нь хариуцсан ажилдаа эзний ёсоор өөриймсөг хандаж, хурдан шалмаг, үйлчлэх нь үнэхээр бахархмаар. Худалдан авагч орж ирэнгүүт «морилогтун» гэж эгээтэй л өөрсдийнхөө найз нөхөд, хамаатан садангууд орж ирж байгаа мэт ялдамхан мишээсээр мэхийн ёсолж мэндчлэн угтаж, энэ бараа ийм, тэр бараа тийм гэх зэргээр тайлбарлах, барааг худалдан авсан хэн бүхэнд баярласан талархснаа илэрхийлэх, дахин ирж үйлчлүүлэхийг хүсэх зэрэг нь ийм үйлчилгээ үзээгүй миний хувьд их л ер бусын сайхан санагдаж байв.

Загасыг загасныхаа тасгаас худалдан аваад, хагас боловсруулсан бүтээгдэхүүний тасагт аваачин өөрсдийн хүслээр боловсруулалт хийлгэнэ. Боов хийхэд бүх материалаа дэлгүүрээс бэлнээр аваад л хийх жишээтэйгээр дэлгүүрийн нь бүх тасаг, дамжлагууд харилцан уялдаатай юм.

Нэгэн удаа худалдан авагч ирээд «өчигдөр авсан загас бага зэрэг муудсан байсныг хэлэхэд тус тасгийн 3 ажилчин гурвуулаа машид сандран, уучлалт гуйж, хамгийн үнэтэй бараагаа тэр хүний торонд хийж, дахин ирж үйлчлүүлэхийг хүсэн мэхийсээр үдэж билээ. Ажиглаад байхад аль ч тасагт сул зогсолт гэж байдаггүй бололтой. Хүн бүр өөр өөрсдийн хийх ажлыг гаргууд сайн мэдэхийн зэрэгцээ хажуугийн хэн нэг нь ачаалал ихтэй байгаа тохиолдолд хамжин туслах юм. Мөн ажлын цагаар ийш тийш дэмий сэлгүүцэх, уурлаж уцаарлах явдал огт гардаггүй бололтой. Энэ бүхэн нь манай үйлчилгээний газруудад нэвтрүүлүүштэй зүйл мэт санагдлаа. Ажиллах хугацаандаа «тэрийг хий», «тэг, ингэ» гэж зааж захирч байхыг ер сонссонгүй.

Худалдагчид борлуулагдаагүй үлдсэн барааг орой нь өөрсдөө үнэ тогтоон хямдруулж зарна. Маргаашийнхаа ажлын бэлтгэлийг оройдоо хийнэ.

Бас нэг анзаарагдсан зүйл гэвэл, япончууд барааны баглаа боолтын үзэмжинд онцгой анхаардаг бөгөөд энэ нь худалдан авагчийн сэтгэлд хир зэрэг таашаагдсанаар бараа таваарын гүйлгээнд шууд нөлөөлдөг гол хүчин зүйл болдог байна.

Хөдөлмөрчдийн цагийг хэмнэж, ачааллыг хөнгөвчлөх зорилгоор хүнсний дэлгүүр дотроо бусад үйлчилгээ тухайлбал, хими цэвэрлэгээ гэрэл зураг угаах хэсгүүд ажиллах юм. Долоо хоногийн 3 өдөр барааны үнийг хямдруулж энэ тухайгаа мэдээлсэн рекламьг сонины хавсралт болгон тараадаг. Хүмүүсийн утсаар өгсөн захиалгыг авч гэрт нь үнэ төлбөргүй хүргэж өгнө, захиалга ч чамгүй их ирэх юм.

Ажилчдыг тусгай курс, сургуульд суралцуулалгүй шууд үйлдвэрлэл дээр дадлагажуулах явдал зонхилдог. Орон тооны ажилчдаас гадна цагийн ажилчид (пато) байх бөгөөд түүнд голчлон хүнтэй сууж, хүүхэд гаргасан эмэгтэйчүүд ордог байна.

Тэндхийн ажилчин эмэгтэйчүүдтэй ярилцаж байхад Монгол эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэг адил цалин авдаг тухай сонсоод итгэж ядан гайхацгааж байв. Япон эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ бага цалин авдаг учрыг дэлгүүрийн даргаас лавлахад цалингийн ялгаа нь хийж буй ажлаас нь шалтгаалж байгаагаар тайлбарласан юм. Адилхан ажил хийсэн тохиолдолд яах эсэхийг дахин асуухад, адилхан ажил хийнэ гэж байдаггүй, гэсэн хариулт сонсов.

Китами хотод байх хугацаандаа япончуудын хуримын ёслолд оролцож үзэв. Тэд хуримаа зочид буудалд хийх ажээ. Хуриманд оролцогсдод юуны түрүүн хуримын танилцуулга тараана. Хуримынхаа цар хүрээнээс шалтгаалж оролцогсод тодорхой хэмжээний мөнгөн хандив өгдөг нь манай хуримын ёсноос ялгаатай санагдав. Миний оролцсон хуримын ажиллагаанд 6500 иен буюу 30 гаруй ам. доллар хандивлаж байлаа. Урьдчилан тараасан танилцуулгад ирэх зочин бүрийн суудлыг нэг бүрчлэн заасан байв. Уг танилцуулгад залуу хосын зураг, биеийн жин, өндөр, ааш зангийнх нь онцлог, авьяас сонирхол зэргийг маш энгийн мөртлөө шог хошин өнгө аясаар бичжээ. Үүнээс гадна төрсөн он сар, төгссөн сургууль, анх хаана, хэзээ уулзсан, нэг нэгнийгээ хараад тэдэнд төрсөн анхны сэтгэгдэл, бие биендээ хүсэх зүйл, эцэг эхдээ хэлэх үг зэргийг хүснэгтэнд бичиж харуулжээ. Хамгийн сүүлийн хуудсан дээр залуу хосоос хүрэлцэн ирсэн зочдод хандаж «Бидний хуриманд өнөөдөр зав чөлөө гарган хүрэлцэн ирсэн явдалд зүрх сэтгэлээсээ баярлаж байна. Маргаашнаас бидний шинэ амьдрал эхэлнэ. Бид хоёрын амьдралд ямар нэг саад тотгор тохиолдвол бие биенээ харилцан тулж түшиж явна. Сайн сайхан гэр бүл болохын төлөө бүх хүчээ зориулна. Та бүхэнд их баярлалаа» гэж бичжээ.

Хуримын явцад залуу хосууд 3 удаа хувцсаа сольж өмсдөг заншилтай юм. Эхлээд урт ханцуйтай кимоно, дараа нь богино ханцуйтайг, хамгийн сүүлд европ маягийн хуримын хувцас өмсдөг ажээ.

Китами хотын нэгэн дунд сургууль дээр очиж үзлээ. Тус хотод дээд шатны 7 сургууль, 11 дунд, 20 бага сургууль байдаг юм байна. Миний очсон сургуульд 500 сурагч, 28 багш, үүний 3 нь эмэгтэй байв. Сургалтын 9 жилийн боловсрол олгодог дунд сургууль нь хүүхдийн хүмүүжлийн хамгийн хариуцлагатай газар болдог байна. Хүмүүжлийнхээ ажилд энэрэнгүй үзэлтэй, зөв боловсон хүмүүжилтэй, бие биедээ харилцан тусалдаг хүнийг төлөвшүүлэхэд голлон анхаардаг ажээ. Дуу хөгжмийн хичээлд орж үзэхэд кабинет нь дэлхийн сонгодог хөгжмийн зохиолчдын хөргүүд өлгөөстэй байна. Сурах бичиг нь маш авсаархан хэрнээ гүн утга агуулгатай юм. Ямар нэг дууны үгийг нотынх нь хамт бичээд, буланд нь хөгжмийн зохиолчийнх нь намтар уран бүтээлээс мөн товч тодорхой танилцуулсан байв. Ер нь хичээл дээр сууж үзэхэд сурагчдын сэтгэн бодох, бие даах чадварыг хөгжүүлэхэд их анхаардаг байна. Сургуулийн сурагчидтай уулзахад танихгүй хүнээс бишүүрхэх, ичиж зовох, буруу юм хэлчих бий, алдчих бий гэж ер биеэ барьж бишүүрхэхгүй харин тэднээс аль болохоор их л зүйл мэдэж авахыг эрмэлзэх юм. Түүнээс гадна хүүхдүүд нь маш цэвэрхэн нямбай

хувцаслаж, дэвтэр, ном, сурагчийн хэрэглэлтэйгээ их гамтай харьцдагийг нүдээрээ үзлээ.

Китамигаас машинаар 2 цаг гаруй яваад Сарома гэдэг нуурын дэргэдэх загасчдын тосгонд хүрч очдог. Тэнд очиж, загас барьж завиар явж үзлээ. Миний танилцсан загасчин тайван шулуун зантай, монгол хүнтэй маш адилхан хөрслөг бор царайтай хүн байв. Түүний жилийн орлого 40 сая иен ажээ. Загасчид 200 хүнтэй «хоршоололд» хамаарагдан тусгай төлөвлөгөөний дагуу ажиллах бөгөөд төлөвлөгөөнөөс илүү хийгдсэн нь шууд тэр хүний орлого болдог байна. Хөдөлмөрийн нөхцөл хүнд боловч орлого ихтэй ажил ажээ. Өвөлдөө ажлын ачаалал багасдаг тул тэрээр Тайвань, Гонконг, Тайланд аялжээ. Уулзах ялдамд Монголд очих сонирхолтой байгаагаа мөн илэрхийлэв. Барьсан загасыг зах дээр аваачиж худалдаалдаг тусгай пүүс байдаг бөгөөд үнийг тэд өөрсдөө тогтооно.

Монголоос хүн ирсэн гэж сонсоод монгол хүнтэй нүүр тулан учирч алс холын Монгол орны тухай яриулах гэсэн хүмүүс маш их байв. Мөн дунд сургуулийн багш Мизуно гэдэг айлынд уригдаж очлоо. Гэргий нь гэрийн ажилтай, 10, 15 насны 2 хүүхэдтэй юм. Тэд намайг хонины махыг хавтгайгаар нь нимгэн зүсээд, халуун ногоо, гоньд давсаар амталсан «Чингис хаан» нэртэй хоолоор дайлав. Ширээн дээр тавьсан хайруулын тогоон дээр махаа шууд шарж иднэ. Тэд хоол идэх зуур Монголын тухай нэлээд зүйл сонирхон асуув. Гэрийн эзэгтэй христос шашныг шүтдэг. Китами хотод христос шашны цэцэрлэг, бага дунд сургууль байдаг бөгөөд бага ангийн хүүхдүүдэд сайн дураар англи хэл заадаг гэнэ. Шашны хичээлд сууж үзэв. Биднийг Иисус Христос бүтээсэн. Бидний сэтгэл зүрхэнд бурхан бий. Бид «зовлонд нэрвэгдсэн хүнд туслах» гэсэн сэтгэлээрээ Иисус Христостой адил. Хүнд тус болсноороо сэтгэл ариусна гэж хичээл дээрээ ярьж байхыг сонслоо.

Мизуно сан-ы бага хүү нь хичээлээс гадуур ардын дууны дугуйланд явдаг гэнэ. Багш нь ямар ч үнэ төлбөргүй, сайн дураараа бийрээр ханз бичих, ардын дуу дуулахыг заадаг юм байна. Өөрийн мэдэж байгаа зүйлээ хойч үедээ сургаж үлдээх, улсынхаа соёлын өвийг арвижуулахын тулд ингэж явна даа гэж тэр багш ярьж байв.

Хоккайдо арал дээр очин япон айлд түр хугацаагаар боловч амьдарч, тэдний дунд орж ажиллаж үзсэн минь япон хүмүүсийн ахуй амьдрал, зан заншлыг мэдэж, сэтгэхүйг нь ойлгоход их тус дөхөм болсныг тэмдэглэхэд таатай байна.

ХОККАЙДО, КИТАМИ ХОТ